



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/1297

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1."Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны явцад хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг мөрдөж ажиллахыг нийт албан хаагч, газар, хэлтсийн дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/, Хяналт шалгалтын газар /Б.Ганзориг/-т тус тус үүрэг болгосугай.


3.Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/1170 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142204234



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГАД ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГААР ШИЙДВЭРЛЭГДЭЖ БАЙГАА
ХЭРЭГ, МАРГААНЫ ЯВЦАД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж буй иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох, хэрэг, маргааны явц, шийдвэрлэлтэд хяналт тавих, хэрэг, маргааны мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/-г хөтлөхөд энэ журмыг баримтална.

1.2.Энэ журмыг улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн дарга, албан хаагчид мөрдөж ажиллана.

1.3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д заасан албан тушаалтан захиргааны хэрэг, маргаанд хариуцагчаар оролцоно.

**Хоёр.Итгэмжлэгдсэн төлөөлөгч,
түүний эрх, үүрэг**

2.1.Иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдуулан хууль хяналтын байгууллагаас иргэн, эрүү, захиргааны хэрэгт тус байгууллагыг хариуцагч, гуравдагч этгээд, гэрч, хохирогчоор татах тухай албан ёсны мэдэгдэл /мэдэгдэх хуудас, албан бичиг/-ийг үндэслэн хэрэг, маргаанд хамаарал бүхий газар, хэлтсийн албан хаагчийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилох Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын итгэмжлэлийн төслийг хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж боловсруулж, батлуулна.

2.2.Төрийн албаны хэрэг, маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилох Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын итгэмжлэлийн төслийг Тамгын газрын эрх зүйн асуудал хариуцсан нэгж боловсруулж, батлуулна.

2.3.Энэ журмын 2.1-д заасан итгэмжлэлийн төслийг аймаг дахь нэгжийн хяналтын улсын байцаагч боловсруулж, нэгжийн даргаар батлуулна.

2.4.Итгэмжлэлийн төсөл боловсруулсан албан хаагч итгэмжлэлийн эх хувь, мэдэгдэх хуудсыг итгэмжлэгдсэн төлөөлөгчид мэдэгдэж, хүргүүлнэ.

2.5.Итгэмжлэгдсэн төлөөлөгч, хариуцагч нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.6.Итгэмжлэгдсэн төлөөлөгч, хариуцагч дараах эрх, үүрэгтэй байна:

2.6.1.итгэмжлэлийг хүлээн авмагц мэдээллийн санд итгэмжлэлийн он, сар, өдөр, нэхэмжлэлийн шаардлагын агуулгын товч утгыг бүртгэж оруулах;

2.6.2.хууль хяналтын байгууллагаас мэдэгдсэн даруйд нэхэмжлэл, хариу тайлбар зэргийг гардан авах, тэдгээрт өгөх хариу тайлбарын төслийг нотлох баримтын хамт бэлтгэн газар, хэлтсийн улсын ахлах бүртгэгч, нэгжийн даргаар хянуулан хуулийн хугацаанд эрх бүхий байгууллагад гарган өгөх;

2.6.3.хэрэг, маргааны талаар улсын бүртгэлийн хувийн хэргийн эх нотлох баримтад үндэслэн судалж, холбогдох тайлбарыг бэлтгэх, тайлбарт шаардлагатай нотлох баримтуудыг архивын хувийн хэрэг, эх нотлох баримтаас бүрэн гүйцэд гаргаж нотлох баримтын шаардлага ханган өгөх;

2.6.4.шүүх хуралд биечлэн оролцох, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжгүй болсон тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлтээ хуулийн дагуу тавьж шийдвэрлүүлэх, энэ талаар газар, хэлтсийн даргад урьдчилан мэдэгдэх;

2.6.5.бие даан шийдвэрлэхэд бэрхшээлтэй, нарийн төвөгтэй асуудлыг холбогдох чиглэлийн газар, хэлтсийн даргад танилцуулан чиглэл, зөвлөмж авах, итгэмжлэгдсэн төлөөлөгч нэмж томилуулах хүсэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад тавьж шийдвэрлүүлэх /аймагт хэлтсийн даргад хандах/;

2.6.6.хэргийн бодит нөхцөл байдал, холбогдох хууль тогтоомжийг сайтар судлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

2.6.7.мэдээллийн санд хэрэг, маргааны явц, шүүх хуралдааны тов, хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын он, сар, өдөр, дугаар, утгыг бүрэн гүйцэт хөтөлж, шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэрийг цахимжуулан оруулах;

2.6.8.хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг, маргаантай холбоотой шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэр, нэхэмжлэл, албан бичиг зэрэг баримт бичгийг улсын бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм, журамд заасныг баримтлан улсын бүртгэлийн хувийн хэрэгт хавсаргаж, баяжилт хийж хадгална.

2.7.Итгэмжлэгдсэн төлөөлөгч, хариуцагч нь хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн мэдэгдэх хуудас, нэхэмжлэл, шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол зэрэг баримтыг мэдээллийн санд тухай бүр оруулахгүй байх, шүүх хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцохгүй байх, маргалдаж буй талуудын аль нэг талд давуу байдал үүсгэх, хувийн харилцаа тогтоохыг хориглоно.

Гурав.Гуравдагч этгээд, гэрч, хохирогчоор оролцож байгаа албан хаагчийн эрх, үүрэг

3.1.Гуравдагч этгээдээр хэрэг, маргаанд оролцож байгаа албан хаагч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2.Иргэний, эрүүгийн, захиргааны хэрэг, маргаанд гэрчээр оролцож байгаа албан хаагч улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдүүлгийг үнэн зөв мэдүүлнэ.

3.3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж хохирогчоор оролцож буй албан хаагч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв.Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны үйл ажиллагаанд хяналт тавих

4.1.Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны явц, мэдээллийн санг хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих ерөнхий чиг үүргийг хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

4.2.Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны явц, мэдээллийн санг хөтлөх үйл ажиллагаанд улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч байнгын хяналт тавьж ажиллана.

4.3.Хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой хэрэг, маргааны шийдвэрлэлтэд, төрийн албаны маргаантай холбоотой хэрэг, маргааны шийдвэрлэлтэд дотоод аудит хариуцсан нэгж тус тус дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан хэрэгжүүлнэ.

Тав.Бусад зүйл

5.1.Албан хаагч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан хохирлыг Улсын бүртгэлийн байгууллага хариуцан арилгасан бол өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс хуулийн дагуу шаардаж гаргуулна.

5.2.Шүүхэд өгөх нотлох баримтыг нотариатаар гэрчлүүлэн баталгаажуулсан тохиолдолд холбогдох зардлыг ерөнхий газар, орон нутагт тухайн нэгж хариуцна.

5.3.Энэ журмыг зөрчсөн албан хаагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.